

"Багануур" ХК-ийн Засгийн газрын хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт

/ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2026 оны 05-р сарын байдлаар /

2026-06-04

№	ЗГ-ын хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгавар			Үүрэг даалгаврын тайлан, явц	
	Нэр, огноо, №	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх газар	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /тайлбар/	Ажлын гүйцэтгэл %
1		1. 1.Хүрэн нүүрсийг нам температурт боловсруулан түүхий нүүрсэнд агуулагдах хорт нэгдэл, дэгдэмхий бодисыг бууруулах, утаа багатай хөх нүүрс үйлдвэрлэх зорилгоор Багануур хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах нүүрс-пиролизын үйлдвэрийн бүтээн байгуулалтыг 2025 оны II улиралд багтаан эхлүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус даалгасугай.		Багануур ҮТП-д шаардлагатай газрын асуудлыг НИТХ-ын 2025 оны 02-р сарын 26-ны тогтоолоор шийдвэрлэж, ЗГ-ын 2025 оны 03-р сарын 20-ны тогтоолоор 2 байршилд 636 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. "Эрдэнэс Монгол", "Багануур" ХК болон "Эрдэнэс ҮТП"-ийн холбогдох ажилтнууд орсон ажлын хэсгийг байгуулан тендерийн даалгаварыг боловсруулсан.	100
2	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-01-14 Дугаар 2025_20	3. 3.Нүүрс-пиролизын үйлдвэр"-ийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж, гүйцэтгэгчээр олон улсад туршлагатай, технологи эзэмшигч бүхий этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг шуурхай зохион байгуулж, 2025 оны II улиралд багтаан дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус даалгасугай.	Эрдэнэс ҮТП ХХК, Багануур ХК	Нүүрс-пиролизын үйлдвэр"-ийг бүтээн байгуулах ажлын хэсгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна . Үүнд: 1. Ажлын хэсгээс боловсруулсан тендерийн даалгаварыг үндэслэн олон улсын нээлттэй тендерийг 2025 оны 3-р сарын 8-нд зарлаж 4-р сарын 8-ны өдөр нээхэд 2 оролцогч орж амжилттай болсон. “Сэдин инженеринг Монголиа” ХХК 1,600,000,000 төгрөг “Смарткрафт” ХХК 2,000,000,000 төгрөг 2. Тендерийн үнэлгээ хийгдэж БНХАУ-н “SEDIN ENGINEERING” компани шалгарч ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс Монгол” нэгдлээс санхүүжүүлэн 2025 оны 4-12-р сарын хугацаанд гүйцэтгэсэн. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар шинжээч нар томилогдон ажилласан. 3. Нүүрс пиролизын үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэгч БНХАУ-н “Сэдин инженеринг” компанитай хамтран мэдээллээр ханган ажиллаж төслийн ТЭЗҮ-ийг хийж дуусган АҮЭБЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2026 оны 02-р сарын 12-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.	100
3		4. 4.Нүүрс-пиролизын үйлдвэр” ашиглалтад орсны дараа үйл ажиллагаанд шаардлагатай нүүрсийг тогтвортой нийлүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Багануурын уурхайн хүчин чадлыг өргөтгөхтэй холбоотой хөрөнгө оруулалт, санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус даалгасугай.		"Багануур" ХК-иас Нүүрс пиролизын үйлдвэрийг нүүрсээр тасралтгүй хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг яаралтай шийдвэрлэх талаар "Эрдэнэс Монгол" ХХК-д 2025.04.16-ны өдрийн 01/578 тоот, 7-р сарын 31-нд дахин албан бичгийг явуулсан. Эрдэнэс Монгол нэгдлийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 8-р сарын 23-ны өдрийн А/125 дугаар тушаалаар “Эрдэнэс Монгол” ХХК болон “Багануур” ХК-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулж хамтран ажиллаж хөрөнгө оруулалтын асуудлыг тодорхой болгон нийт 239.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дүнг гаргаж 2026-2030 оны хугацаанд үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр “Эрдэнэс Монгол”-д танилцуулсан.	100

ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛ

4		<p>45.5.1. Багануур хүрэн нүүрсний стратегийн ордыг түшиглэн хүрэн нүүрсийг нам температурт боловсруулж, түүхий нүүрсэнд агуулагдах хорт нэгдэл, дэгдэмхий бодисыг бууруулсан, утаа багатай хөх нүүрс үйлдвэрлэх “Нүүрс-пиролизын үйлдвэр”-ийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус;</p>		<p>Багануур ҮТП-д шаардлагатай газрын асуудлыг НИТХ-ын 2025 оны 02-р сарын 26-ны тогтоолоор шийдвэрлэж, ЗГ-ын 2025 оны 03-р сарын 20-ны тогтоолоор 2 байршилд 636 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. “Эрдэнэс Монгол”, "Багануур" ХК болон "Эрдэнэс ҮТП"-ийн холбогдох ажилтнууд орсон ажлын хэсгийг байгуулан тендерийн даалгаварыг боловсруулсан.</p>	100
5	<p>Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэл 2024-12-20 Дугаар 2024_45</p>	<p>45.5.3. Нүүрс-пиролизын үйлдвэр"-ийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх асуудлыг судалж, олон улсад туршлагатай, технологийн эрх эзэмшдэг гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж, дүнг 2025 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус;</p>	<p>Эрдэнэс ҮТП ХХК, Багануур ХК</p>	<p>1. Ажлын хэсгийн боловсруулсан тендерийн даалгаварыг үндэслэн олон улсын нээлттэй тендер 3-р сарын 8-нд зарлаж 4-р сарын 8-ны өдөр нээсэн. Тендерт 2 оролцогч орж амжилттай болсон. “Сэдин инженеринг Монголиа” ХХК 1,600,000,000 төгрөг “Смарткрафт” ХХК 2,000,000,000 төгрөг 2. Тендерийн үнэлгээ хийгдэж БНХАУ-н “SEDIN ENGINEERING” компани шалгарч ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс Монгол” нэгдлээс санхүүжүүлэн 4-12-р сарын хугацаанд гүйцэтгэсэн. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар шинжээч нар томилогдон ажилласан. 3. Нүүрс пиролизын үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэгч БНХАУ-н "Сэдин инженеринг" компанитай хамтран мэдээллээр ханган ажиллаж төслийн ТЭЗҮ-ийг хийж дуусган АҮЭБЯ-ны Эрдэнэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2026 оны 02-р сарын 12-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.</p>	100
6		<p>45.5.4. Нүүрс-пиролизын үйлдвэр"-ийг нүүрсээр хангах ажлыг зохион байгуулж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангаж ажиллахыг “Багануур” ХК (Д.Түвшинжаргал)-д, уурхайн хүчин чадлын өргөтгөлтэй холбоотой хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус.”</p>		<p>"Багануур" ХК-иас Нүүрс пиролизын үйлдвэрийг нүүрсээр тасралтгүй хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын яаралтай шийдвэрлэх талаар "Эрдэнэс Монгол" ХХК-д 2025.04.16-ны өдрийн 01/578 тоот, 7-р сарын 31-нд дахин албан бичгийг явуулсан. Эрдэнэс Монгол нэгдлийн ГЗ-ийн 2025 оны 8-р сарын 23-ны өдрийн А/125 дугаар тушаалаар “Эрдэнэс Монгол” ХХК болон “Багануур” ХК-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулж хамтран ажиллаж хөрөнгө оруулалтын асуудлыг тодорхой болгон нийт 239.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын дүнг гаргаж 2026-2030 оны хугацаанд үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр “Эрдэнэс Монгол”-д танилцуулсан.</p>	100

7	Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-07-23 Дугаар 2025_28	6. Багануур уурхайг түшиглэсэн “Нүүрс-хими, Кокс химийн цогцолбор”-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, явц, үр дүнг 2025 оны 3 дугаар улиралд багтаан засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт)-д тус тус;		Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.	100
8	Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-08-27 Дугаар 2025_61	5.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой тогтоох, удирдлагын зардал, орон тоог бууруулах зорилгоор зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах болон чиг үүргийн давхардалтай, үр ашиггүй хуулийн этгээдүүдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах замаар орон тоог 10-аас доошгүй хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 15-аас доошгүй хувиар бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулж, холбогдох шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор оруулж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрчист Монгол” ХХК болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нарт тус тус үүрэг болгосугай.	Багануур ХК	<p><u>1.</u> Компанийн ажлын байрны чиг үүргийн давхардлыг арилгах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор зохион байгуулалт бүтэц өөрчлөлт оруулах саналаа ТУЗ-д оруулж 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцийг батлуулсан.Бүтэц зохион байгуулалтаар ажилтны тоо 1122 байсныг 1104 болгон 22-оор бууруулж удирдах ажилтныг тоог 5-аар цөөрүүлсэн.</p> <p><u>2.</u> Зардлын үр ашиг, санхүүгийн сахилга батыг сайжруулах хүрээнд үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой зардлуудад дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бууруулах боломжтой болон тэвчиж болохуйц зардлуудыг тодорхойлон бизнес төлөвлөгөөний тодотголын саналд тусган ажиллаж байна..</p>	100
9		6.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дэргэдэх нийгмийн шинжтэй, ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, нэгжийг өөрчлөн зохион байгуулах, бие даасан хуулийн этгээдийн хэлбэрт шилжүүлэх, илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг нь хувьчлалаас гадуур худалдан борлуулах талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрчист Монгол” ХХК-д тус тус даалгасугай.		2026 оны эхний хагас жилийн эргэлтийн хөрөнгийн тооллогоор 10.7 тэрбум төгрөгийн ашиглах бараа материалын жагсаалтыг гаргасан.Үүнийг зарж борлуулах эрхийг компанийн гүйцэтгэх удирдлагад олгосон нөхцөлд ашиглах бараа материалын үлдэгдлийг бууруулах боломжтой болно.	50

10	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 14 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-27 Дугаар 2025_14	20.2.1 "Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн хэмжээн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтыг хойшлуулах замаар 4 их наяд төгрөгийг төвлөрүүлэх болон улс, орон нутгийн төсөвт оруулж, татварын орлого, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын! Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд.		2026 оны 1-р улиралд хойшилсон хөрөнгө оруулалт байгаагүй бөгөөд борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нүүрсний үнийг нэмэгдүүлэх санал, холбогдох албан бичгийг 2026 оны 5 дугаар сард Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн.	50
11		20.2.1 "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдүүдийн засаглал, үр ашгийг сайжруулах хүрээнд бүтцийг оновчтой тогтоох, шинэчлэл хийх зорилгоор үр ашиггүй, чиг үүргийн давхардалтай хуулийн этгээдүүдийг нэгтгэх, татан буулгах, шилжүүлэх, захиргааны болон удирдах ажилтны тоог бууруулах, нэгдлийн хэмжээнд ажлын үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын систем нэвтрүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд.	Багануур ХК	"Эрдэнэс Монгол" ХХК-иас хуулийн этгээдүүдийн засаглал, үр ашгийг сайжруулах зорилгоор бүтцийг оновчтой тогтоох, шинэчлэл хийх, үр ашиггүй, чиг үүргийн давхардалыг арилгах чиглэл өгсний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: 1. Чиг үүргийн давхардалыг арилгах зорилгоор ЗГ-аас үүрэг болгож 2026 оны 2-р сарын 1-ээс томилогдсон 3 менежер болон 2 газрын даргыг чөлөөлсөн. 2. 2026 онд 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 тоот тогтоолоор компанийн орон тооны дээд хязгаарыг 1104 байхаар тогтоосон. Үүнийг тодруулбал компанийн ажилтны тоо 1122 байсныг 1104 болгон 22-оор бууруулж удирдах ажилтныг тоог 5-аар цөөрүүлсэн. 3. Багануур ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай Багануур Илч ХХК-ийг ТУЗ-ийн 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 25 тоот тогтоолоор "Багануур" буулгах шийдвэр гаргуулж компанийг татан буулгах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж байна.	100
12	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	28.15 Уулын ажилд нэн шаардлагатай тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох аммиакийн шүүний импорт багассантай холбогдуулан тэсрэх бодисын нөөцийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор нүүрсний уурхайнуудыг шаардлагатай тэслэгээний материалаар хангах асуудлыг хууль, журмын дагуу нэгдлийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт)-д		Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөгөөнд тусгасан үнээр тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох аммиакийн шүүг худалдан авах боломжгүй болж, тодотгол хийж нэгж үнийг тухайн үеийн зах зээлийн үнээр тооцож 2025 оны 10-р сард тендер зарлан 1393.9 тн, 12-р сард тендер зарлан 1200тн аммиакийн шүүний нөөцийг бүрдүүлэн ажилласан.	100

13	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-03-18 Дугаар 2026_10	“Эрдэнэс Монгол” ХХК, төрийн өмчит уул уурхайн компаниудад дотоод хэрэгцээний шатахууны нөөц бүрдүүлэх, хадгалах агуулах, сав барих ажлын тооцоо, судалгаа хийж шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Аж үйлдвэр эрдэс баялгийн сайд Г.Дамдинням болон “Эрдэнэс Монгол” ХХК (Б.Даваадалай)		“Багануур ХК нь 2026 оны 5-р сарын байдлаар дотоодын хэрэгцээний 1375 тонн дизель түлш хадгалах багтаамжтай агуулах савтай үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн Нэг сарын хэрэгцээт түлшний нөөц бүрдүүлэх үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн тулд одоогийн хүчин чадал дээрээ нэмж 400 тонн түлш хадгалах шинэ сав барьж байгуулах шаардлага үүссэн. Энэхүү ажлын хүрээнд Түлш хадгалах сав (резервуар) үйлдвэрлэх, угсрах ажлын үнийн санал авах зарыг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр компанийн албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулсан боловч одоогоор ямар нэгэн үнийн санал ирээгүй байна.	70
14	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн 14 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-04-15 Дугаар 2026_14	1.Эрдэнэс: Монгол” нэгдлийн хэмжээнд олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд шаардлагатай түлш шатахууны 2-3 сарын хугацааны стратегийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК, “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн уурхайн дэргэд түлш шатахууны агуулах, хадгалалтын сав барих ажлыг тооцоо, судалгаанд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү), гүйцэтгэх удирдлага (Б.Даваадалай)-д:			70

ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

15	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02	1.2.20.нүүрс-химийн технологийг эзэмшихэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, томоохон төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох зорилгоор туршилт судалгааны бага оврын үйлдвэр байгуулах, “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр”-ийн төслийн хүрээнд түүхий эдийн нарийвчилсан шинжилгээ, туршилт судалгааг эхлүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нарт;	Эрдэнэс ҮТП ХХК, Багануур ХК	Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ирүүлсэн 2025 оны 4-р сарын 4-ний өдрийн 03/79 тоот албан бичгийг үндэслэн Багануурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн Нүүрс-пиролизын үйлдвэрийг байгуулах ажлын хүрээнд үйлдвэрлэлийн бүрэн хэмжээний туршилтыг ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэнтэй хамтран БНХАУ-ын Нүүрс-пиролизын үйлдвэрт хийлгэхээр тохиролцсоны дагуу Багануурын хүрэн нүүрсний ордыг төлөөлөхүйц 360.0 тн нүүрсийг шуудайлан 2026 оны 03-р сарын 16-ны өдөр бэлтгэн нийлүүлж явуулсан. Хагас үйлдвэрийн туршилтийг БНХАУ-ын нүүрс боловсруулалтын төв Шаньси мужийн Нүүрс пиролизын үйлдвэрт 2026 оны 5-р сарын 12-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.	100
----	---	---	------------------------------	--	-----

16	<p>ЗАСГИЙН ГАЗРЫН 2024- 2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02</p>	<p>1.2.21.Багануурын уурхайг түшиглэсэн “Нүүрс-химийн цогцолбор”-ын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах олон улсын тендерийн баримт бичгийг боловсруулж, сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл хангахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нарт;</p>	<p>Эрдэнэс ҮТП ХХК, Багануур ХК</p>	<p>1. Ажлын хэсгийн боловсруулсан тендерийн даалгаварыг үндэслэн олон улсын нээлттэй тендер 3-р сарын 8-нд зарлаж 4-р сарын 8-ны өдөр нээсэн. Тендерт 2 оролцогч орж амжилттай болсон. “Сэдин инженеринг Монголиа” ХХК 1,600,000,000 төгрөг “Смарткрафт” ХХК 2,000,000,000 төгрөг 2. Тендерийн үнэлгээ хийгдэж БНХАУ-н “SEDIN ENGINEERING” компани шалгарч ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс Монгол” нэгдлээс санхүүжүүлэн 4-12-р сарын хугацаанд гүйцэтгэсэн. Төслийн ТЭЗҮ, зураг төслийг АҮЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулахаар шинжээч нар томилогдон ажилласан. 3. Нүүрс пиролизын үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэгч БНХАУ-н "Сэдин инженеринг" компанитай хамтран мэдээллээр ханган ажиллаж төслийн ТЭЗҮ-ийг хийж дуусган АҮЭБЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2026 оны 02-р сарын 12-ны өдөр хэлэлцүүлэн батлуулсан.</p>	100
----	---	--	---	---	-----

ХЯНАСАН: ДХЭУА-НЫ ДАРГА

НЭГТГЭСЭН: ДХЭУА-НЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.ХАЖИДМАА

Б.НАРАНЦЭЦЭГ